



Камерон МакРей

Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал

Олборлох салбарын тогтвортой байдал – боломжууд, тулгарч буй саад бэрхшээл, цаашид хөгжүүлэх арга замууд – Оюу Толгойн бодит жишээ

Монголын Тогтвортой Санхүүгийн Чуулган - 2013 оны 5-р сарын 15

Танилцуулга

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Рио Тинто болон Оюу Толгой ХХК-ийн нэрийн өмнөөс энэхүү чухал арга хэмжээнд оролцож, үг хэлэх боломж олдсонд баяртай байна.

Оюу Толгойд болж буй үйл явдлын тухай ярьж тайлбарлахаас илүүтэйгээр бодитоор харуулах нь зүйтэй гэж үзлээ. Тиймээс Оюу Толгой дахь үйл ажиллагаа болоод улс орон, ард иргэдийн амьдрал ахуйд энэ төслийн үзүүлж буй үр нөлөөг дүрслэн харуулсан гэрэл зургуудыг та бүхэнд үзүүлэхээр бэлтгэлээ.

Түүхийн хуудсыг сөхөхүй

Тогтвортой байдал гэдэг бол ихээхэн хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт. Эдийн засгийн хөгжил, өсөлтөд ихэвчлэн саад тотгор болдог гэж үздэг байсан энэ ойлголт өөрчлөгдөж, бизнесийн хариуцлагатай байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулдаг, өсөн хөгждөг үндсэн зарчим болж чаджээ.

Рио Тинто болон олон жилийн турш үйл ажиллагаа явуулж байгаа бусад компаниуд энэ талаар урт удаан хугацааны арвин түүх, баялаг хүримтлүүлжээ.

Рио Тинтогийн хувьд ч энэ өөрчлөлтийг дагаж, хувьсан өөрчлөгдсөн. Бид аж үйлдвэрийн хувьсгалын ид оргил үед үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тухайн үед богино хугацааны хөгжил, бизнесийн ашгийг илүүд үздэг байсан. 1870 оны үед Испани улсын Хуэльва дахь манай анхны уурхайн талбайгаар дайран үрсч байсан Улаан гол буюу Рио Тинто гэсэн нэрээр бид овоглох болсон түүхтэй.

Гэхдээ цаг хугацаа өнгөрөх тусам компаниуд тогтвортой, хариуцлагатай байдалд дасан зохицож өөрчлөгдөх, эсвэл хаалгаа барих замын аль нэгийг сонгох болсон юм.

Рио Тинто компани тогтвортой байдал бизнесийн салшгүй нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч сүүлийн хорин хэдэн жилийн хугацаанд хувьсан өөрчлөгдөж, хөгжиж ирлээ. Бид байгаль орчин, хүний эрх, эдийн засгийн хөгжил, бизнес явуулж буй улс орнуудтайгаа хамтран ажилладаг гэх зэргээр бизнесийн тогтвортой байдлын арга ажиллагаагаараа дэлхийн хэмжээний манлайлагч болж чадлаа.

Бид уул уурхайн олон шинэ төслийг эхлүүлээд байна. Хамгийн ойрын жишээ болох Оюу Толгой төслөөр дамжуулан энэхүү тогтвортой үйл ажиллагааг эхнээс нь хэрэгжүүлж байгаагаа дэлхий дахинд харуулах боломжтой гэж үзэж байна.

Уул уурхайн бизнес эрхлэгчдийн хувьд энэ нь үргэлж амар, хялбар байгаад байдаггүй ч бид бизнесээ явуулахын зэрэгцээ тогтвортой байдлыг ямагт хөгжүүлэх учиртай. Харин төсөл хэрэгжүүлж буй улс орны нөхцөл байдал, манай ажиллах хүчин биднийг тогтвортой байдлын зарчмыг мөрдөн ажиллахад гол чиглэл өгч байна.

Төслийн санхүүжилт ба олон улсын санхүүгийн байгууллагууд

Оюу Толгойн хэмжээний томоохон төслийг хэрэгжүүлж буй компаниудад тулгарч буй бас нэг чухал хүчин зүйлийг дурьдмаар байна. Энэ бол олон тэрбум долларын хөрөнгө оруулалт бүхий санхүүгийн салбар нь бизнесийн тогтвортой, ил тод байдлыг бий болгож байгаа нь бидний хувьд ихээхэн түлхэц болж байна.

Энэ танхимд хүрэлцсэн ирсэн та бүхний олонх нь олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмждэг төсөлдөө нэвтрүүлдэг тогтвортой байдлын шаардлагыг сайн мэдэх байх аа. Харин энэ талаархи мэдээлэл олон нийтэд тийм ч хангалттай биш гэж бодож байна.

Рио Тинто компани уул уурхайн бизнесүүдээ өөрийн нэвтрүүлсэн өндөр түвшний стандартаар удирдан зохион байгуулдаг. Гэхдээ төсөл хэрэгжүүлж буй орны эрх ашиг, хамтрагч талуудын үр ашиг, байгаль орчныг хамгаалах талаар илүү өндөр түвшний стандартуудыг мөрдөж ажиллахыг олон улсын санхүүгийн байгууллагууд шаарддаг.

Бид Оюу Толгойн далд уурхайг барьж байгуулан Монгол улсад олон тэрбум долларын хөрөнгө оруулалт бүхий төслийн санхүүжилтийн багцыг боловсруулах ажлаа үргэлжлүүлж байгаа. Тавьсан шаардлага, стандартуудыг нь бүрэн биелүүлсэн тохиолдолд л Олон Улсын Санхүүгийн Корпораци зэрэг санхүүгийн байгууллагууд төслийн санхүүжилтэд оролцох нь тодорхой.

Эдгээр байгууллагууд чанга хатуу шаардлага тавьж буй ч санхүүжүүлж буй төслүүд нь тогтвортой байдлын талаарх олон улсын өндөр түвшний стандарт, шаардлагыг ханган биелүүлэх, эсвэл давуулан биелүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллаж байгаа нь олзшүүрхүүштай. Тэд оруулсан хөрөнгөдөө тогтмол хяналт, шаардлага тавьж ажилладаг. Энэ нь зөвхөн хөрөнгө оруулалтыг авах үеийг хамраад зогсохгүй, хөрөнгө зарцуулах үеийг ч давхар хамардаг.

Энэ нь Монгол улсын болон компанийн хууль, стандарт журмуудыг зөв зохистой ёс суртахууны өндөр хэм хэмжээнд авч хэрэгжүүлэхээс гадна дэлхийн хэмжээний бизнесийн тогтвортой байдлын зарчмыг мөрдөн ажиллахад биднийг хөтөлж байна. Энэ нь мөн бидний үйл ажиллагаагаа явуулах үндсэн зарчимтай яв цав нийцэж байгаа юм.

Рио Тинто болон Оюу Толгой нь бизнесийн тогтвортой ажиллагааг ямагт талархан хүлээж авдаг. Үүнийг хийвэл ер нь зөв зүйтэй юм байна гэдэг үүднээс бус, харин ирээдүйд амжилттай ажиллах бизнесүүд энэ зарчмаар ажиллах ёстой гэдгийг бид ойлгож, ухамсарлаж байгаа учраас ийнхүү бүхий л үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Хязгаарлагдмал нөөц бүхий хувьсан өөрчлөгдөж буй ертөнцөд энэ нь өөрчлөгдөн хувьсч, хөгжин дэвжих цорын ганц арга зам мөн.

Төслийн хэрэгжилтийн талаар

Энэ олон стандарт, өндөр шаардлагууд бодит байдал дээр хэрхэн хэрэгждэг бол? Үүнийг хариултыг Оюу Толгойгоос харж болно. Учир нь, энэ төсөл дээр эдгээр стандарт, шаардлагууд бодитоор хэрэгжиж байна.

Оюу Толгойд бид стандарт, журмуудыг бодит амьдрал дээр хэрэгжүүлж, тавьсан зорилгоо үйл хэрэг болгож, Монгол улсад үрт хугацааны эерэг нөлөө бүхий ашиг тус, үр өгөөжийг бий болгож байна.

Ажилчдынхаа аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж байгаа, эдийн засгийн хөгжилд ямар хувь нэмэр оруулж байгаа, байгаль орчны менежмент болон оролцогч талууд, орон нутгийн ард иргэдтэй ямар түвшинд харилцаж байгаа талаар хэдэн жишээ дурьдъя.

Аюулгүй ажиллагаа

Тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж, хамтын үнэ цэнийг бий болгох ажлыг төслийн хамгийн үнэт зүйл болох ажилчид буюу хүмүүстээ анхаарал тавихаас эхлэх ёстой.

Ажилчдынхаа аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах нь манай эн тэргүүний зорилт билээ.

Осол, гэмтэлгүй, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх нь бидний гол зорилго. Оюу Толгойд тухайн ажлыг хийх нь аюултай санагдвал ямар ч тохиолдолд уг ажлыг хийхгүй байх, зогсоох тухай хамгийн энгийн зарчим үйлчилдэг.

Осол гэмтлийг арилгах энэ зорилгод хүрэх зам, үрт удаан хэдий ч бид эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд чиглэсэн компанийн соёлыг бий болгон хөгжүүлж байна. Компанийн хэмжээнд энэ соёлыг бодитойгоор түгээж, төлөвшүүлэхийн тулд маш үр дүнтэй, бүтээлч харилцааны аргыг ашиглаж байна.

Саяхны жишээ гэвэл, дуучин Quiza-тай хамтран аюулгүй ажиллагааны тухай дууны клип гаргаад байна. Энэ дуунд компанийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн стандартууд болон хувь хүмүүсийн үүрэг хариуцлагын талаар өгүүлсэн байдаг. Ажилчид уг дууг талархалтайгаар хүлээн авсан. Энэ бол аюулгүй ажиллах ойлголтыг ажилчдад төлөвшүүлэх ихээхэн үр дүнтэй харилцааны олон аргын нэг юм.

Монгол залуусын санаачилгаар бүтээсэн хүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах сэдэвтэй энэ дуу Рио Тинто группийн хэмжээнд өргөнөөр тархаж, одоогоор дөрвөн хэл дээр орчуулагдаж, таван тивд цацагдаад байна.

Монголоос төрж гарсан энэ урлагийн бүтээл Рио Тинто группийн хэмжээнд эерэг нөлөө үзүүлж байгаа нь Оюу Толгойнхон бидний бахархал. Та энэ дууныг клипийг Оюу Толгойн сошиал медиа буюу YouTube хуудаснаас үзэж болно.

Эдийн засгийн хөгжил

Ирээдүйд Оюу Толгой Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувийг дангаар бүрдүүлэх тооцоо, таамаг бий. Оюу Толгой төсөл бүтээгдэхүүнээ борлуулж хараахан эхлээгүй ч улсад орлого төвлөрүүлж, эдийн засгийн үр өгөөжөө өгч байна.

Оюу Толгойн барилгын ажил эхэлснээс хойш 870 сая гаруй ам.долларыг татвар, зээл, урьдчилгаа төлбөрийн хэлбэрээр улсад төвлөрүүлээ. Монгол улсын Засгийн газар болон МҮХАҮТ-аас шалгаруулсан 2012 оны хамгийн их татвар төлсөн аж ахуйн нэгжүүдийн жагсаалтад Оюу Толгой аман хүзүүдсэн. Оюу Толгой төсөл орлого олоогүй байхдаа л улсын эдийн засагт ийнхүү хувь нэмрээ оруулж байгааг дурьдах нь зүйтэй байх.

Оюу Толгойн оруулж буй эдийн засгийн үр өгөөж нь улс орны тогтвортой өсөлт, орчин үеийн дэд бүтцийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, гэрэлт ирээдүйд хөтөлж байгаа гэдэгт итгэж байна.

Гэхдээ Оюу Толгойгоос улсад төвлөрүүлж буй татвар, хураамж нь Монгол улсын эдийн засагт үзүүлж буй цор ганц хувь нэмэр гэвэл өрөөсгөл дүгнэлт болно.

Бид Монгол улсын боловсролын салбарт мэдлэг чадвар, цаг хугацааны хөрөнгө оруулалт хийхээс гадна 126 сая ам.долларын бодит хөрөнгө оруулалт хийгээд байна. Орон даяар олон мянган ажилгүй залуусыг мэргэжилтэй боловсон хүчин болгох, Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг барьж байгуулах, шинэчлэн засварлах, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулах, уг салбарын багш нарын үр чадварыг сайжруулах зэрэг олон үйл ажиллагаа энд багтаж байна. Бидний энэ хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхайн салбарт ашиг тусаа өгөөд зогсохгүй, инженер, барилга, санхүү, мэдээллийн технологийн зэрэг өөр олон салбарт ашиг тусаа өгч, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Үндэсний болон Өмнөговь аймгийн ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, жижиг, дунд бизнесийг дэмжих бидний үйл ажиллагаа ч мөн адил ашиг тусаа үзүүлж байгаа билээ. 2012 оны байдлаар Оюу Толгой ХХК-ийн нийт ханган нийлүүлэгчдийн 67 хувийг Монголын үндэсний аж

ахуйн нэгж эзэлж байна. Эдгээр компаниудтай хамтран ажилласнаар бидний үзүүлж байгаа эерэг нөлөө өсөн нэмэгдэж, улсын хэмжээнд тогтвортой ирээдүйг бий болгоход бодит хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэж байна.

Хүрээлэн буй орчин

Бизнесийн төрөл, үйл ажиллагааны онцлог, газар зүйн байдал, нутаг орны онцлогоос шалтгаалж байгаль орчинд үзүүлж байгаа аливаа нөлөөллийг бид онцгой анхаарч ажилладаг. Бид Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бусад уурхайгаас илүү өндөр түвшний байгаль орчны стандартыг ханган биелүүлдэг.

Ус бол говь нутагт хамгийн үнэтэй эрдэнэ. Тиймээс бид усны хэрэглээнд онцгой анхаарч чамгүй их хөрөнгө мөнгө зарцуулж байна. Энэ ажлын хүрээнд усны хэмнэлт бүхий орчин үеийн уул уурхайн арга ажиллагаа, технологийг нэвтрүүлээд байна. Ахуйн хэрэглээний ус болон үйлдвэрт ашигласан усны 80 хувийг дахин боловсруулж ашигладаг. Оюу Толгойнхон бид дэлхий дээр хамгийн их усны хэмнэлт, хамгийн бага усны хэрэглээ бүхий зэсийн уурхайнуудын нэг болох зорилт тавин ажиллаж байна.

Оюу Толгой дахь усны хэрэглээнд гурван тал ашиглалт, хяналт тавьж ажилладаг. Үүнд, Монголын Засгийн газар, төслийн санхүүжүүлэгчид, манай өөрийн хяналтын үйл ажиллагаа багтана.

Бид усны хэрэглээнд хяналт тавих ажлыг улам найдвартай, ил тод болгох үүднээс орон нутгийн иргэдийг уг үйл ажиллагаанд татан оролцуулж эхэллээ.

Манай компанийн Байгаль орчны хэлтсийнхэн Өмнөговь аймгийн хэмжээнд хамгийн анхны хамтын оролцоонд тулгуурласан усны хяналтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ. Энэ бол Оюу Толгой болон Ханбогд сумын малчдын хоорондын түншлэл, харилцааг бий болгоод зогсохгүй малчид худгийнхаа усны талаар өгөгдөл мэдээллийг өөрсдөө цуглуулж, уурхайн эргэн тойрны газрын усны түвшинд гарч байгаа аливаа өөрчлөлтийг тодруулахад Оюу Толгойн ажилтнуудтай хамтран ажилладаг. Олон Улсын Санхүүгийн Корпораци энэ үйл ажиллагааг Монгол улсын уул уурхайн салбарын шилдэг тэргүүний туршлага хэмээн онцлон дүгнэсэн билээ.

Говь нутаг бол үнэхээр онцгой, сайхан газар. Олон мянган жилийн турш дэлхийн хатуу ширүүн дөрвөн улирлыг даван гарсан зэрлэг ан амьтан, өвс ургамал говьд бий. Энэ бүх гайхамшигт зүй тогтлыг ямар нэгэн уурхай буруу менежмент хийж, үгүй хийж орхивол эмгэнэлт явдал болно. Тиймээс манай компани тус бүс нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар өндөр амлалт тавин ажиллаж байна. Сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд барьж байх тухай манай төлөвлөгөөнд төсөл дуусч, уурхайг хаасны дараа хүрээлэн буй байгаль орчин, ан амьтан ордыг анх олсон үеэс илүү олон төрөлтэй, илүү баталгаатай болсон байхаар тооцож байна.

Орон нутаг

Монголчууд тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал гэдэгчлэн Оюу Толгой төсөлд хамгийн ойр байдаг Өмнөговийн малчдад цагаа олсон тусламж, дэмжлэг юунаас ч илүү хэрэгтэй, бид ч олон төрлийн тусламжийг хүргэдэг.

Тухайлбал, бид саяхан малчдын хоршооллын хөгжлийг дэмжих боломжийн талаар судалгааны ажил хийлээ. Эдгээр хоршоонд малчдад тогтвортой, эдийн засгийн шийдлийг үзүүлэх олон сайхан боломж байгаа. Үүнийг нь бид дэмжих боломжтой.

Удахгүй бид хувийн мал эмнэлгийг хөгжүүлэх, малын өвчинд тавих хяналт болон мал аж ахуйг хөгжүүлэх сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.

Хаалтын хэсэг

Оюу Толгой шиг томоохон цар хүрээтэй төслийг хэрэгжүүлэхдээ уул уурхайн салбар дахь бусад өрсөлдөгчдөөсөө ямагт нэг алхам илүү байхыг Рио Тинто эрхэмлэдэг.

Ямар үед, юугаараа илүү байх тухайгаа бид өөрөө өөртөө хийсэн үнэлэлт дүгнэлт, аудитын үйл ажиллагаанаасаа мэдэж авдаг.

Төсөл хэрэгжиж буй улс орнууд болон Засгийн газрын түншүүдтэйгээ хамтран эерэг нөлөөг баталгаажуулж ажиллах үедээ бид юугаараа илүү байж болохоо харж чаддаг.

Санхүүжүүлэгч байгууллагууд өндөр түвшний шаардлага тавих үед бид давуу талаа олж хардаг.

Орон нутгийн иргэд өөрсдийн хүлээлтээ бидэнд сануулах үед бид юу хийх ёстойгоо өдөр бүр харж чаддаг.

Гэхдээ бид тогтвортой байдлыг хөгжүүлж чадсан дэлхийн түвшний бизнесийг бий болгох боломжтой гэдгээ уул уурхайн салбарынханд харуулж чадсан үед бид энэ салбарын тэргүүн эгнээнд байж чадна.

Төслийг хамтран хэрэгжүүлж буй оролцогч талуудын хамтаар бид Монгол улсад уул уурхайн салбарыг урагшлуулан хөгжүүлэхийн төлөө ажиллаж байна. Бид уул уурхайн бусад компаниудын бүх мэргэжил нэгт нөхдүүд дагаж мөрдөх хүсэл эрмэлзэл төрөхүйц үлгэр жишээг бий болгохыг зорьж байгаа билээ.

Уул уурхайн үндсэн бизнес нь хязгаарлагдмал байгалийн нөөцийг олборлож, өргөн хэрэглээнд ашиглагддаг метал, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Гэхдээ үүний цаана, ялангуяа Оюу Толгой шиг томоохон цар хүрээтэй төсөл нь өнөөгийн нийгэм, эдийн засаг, ирээдүй хойч үеийнхэнд томоохон боломж, гэрэлт ирээдүйг нээж өгч байгаа гэдэгт итгэлтэй байна.

Оюу Толгойнхон бид хэлсэн амандаа эзэн байдаг, зарим үед давуулан биелүүлдэг. Бид хийж бүтээхийн төлөө ажиллаж байна.

Баярлалаа.